



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан¹)

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН “ЗӨВХӨН ӨӨРИЙН ХҮСЭЛТЭЭР” МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХАРЬАТААС ГАРАХ БӨГӨӨД ӨӨР УЛСЫН ГАДААД ПАСПОРТ АВСАН ЭСЭХ НЬ ХАМААГУЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2023/0023

Шүүхийн шийдвэрийн огноо: 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр

Шийдвэрийн төрөл: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Ю.Б нь гэрлэлтээ цуцлуулж, хүүхдүүдээ өөрийн асрамжид үлдээх, тэтгэмж авах, гэр бүлийн дундын хөрөнгөөс ногдох хэсгийг гаргуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан бөгөөд ийн маргаж байх явцдаа түүний эхнэр болох Т.Т нь 2004 онд өөр хүнтэй гэрлэлтээ баталгаажуулж байсан талаар олж мэджээ. Иймд нэхэмжлэгч нь өөрийн эхнэрээ ИБУИНХУ-д гэрлэлтээ бүртгүүлсэн байсан, **2013** онд өөртэй нь гэрлэлтээ бүртгүүлэхдээ ИБУИНХУ-ын иргэншилтэй байсан, Улсын бүртгэлийн хэлтэс өмнөх гэрлэлтийг хүчин төгөлдөр эсэхийг шалгалгүйгээр гэрлэлтийг бүртгэсэн нь хууль зөрчсөн гэж маргасан. Хариуцагч Улсын бүртгэлийн хэлтсээс тухайн хүний овог нэр, регистрийн дугаарыг шалгаж үзэхэд “**гэрлэлт бүртгэлгүй**” лавлагаа гарсан, үүнийг үндэслэн гэрлэлтийг бүртгэж, гэрчилгээг олгосон тул улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй гээд бүртгэлийг хүчингүй болгох үндэслэлгүй гэсэн тайлбарыг ирүүлжээ.

Болсон үйл баримтаас дурдвал гуравдагч этгээд болох эхнэр Т.Т нь **2003** онд ИБУИНХУ дахь оюутны визний хугацаа дуусаж, сунгуулахад их хэмжээний төлбөр төлж чадахгүй байсан учраас тухайн улсын цагаачлалын албанд хандаж “өөрийн бичиг баримтыг хаяж үрэгдүүлсэн” гэж өөрийн нэрийг (Монгол Улсад бүртгэлтэй нэр Т.Ч) Т.Т гэж зохиож өргөдөл гаргасан. Үүний дараа **2004** онд өөрийн нэр дээрх байнгын оршин суух зөвшөөрлийг ашиглаж тухайн үед хамтран амьдарч байсан визний зөрчилтэй Л.Б-Э-тэй Монгол Улсаас ИБУИНХУ-д суугаа Элчин сайдын яамны Консулд гэрлэлтээ бүртгүүлж Л.Б-Э-г тус улсад оршин суух байнгын визтэй болгосон. Сүүлд **2011** онд Монгол Улсад өөрийн бүртгэлтэй нэр (Т.Ч)-ийг Т.Т болгож иргэний улсын бүртгэлд бүртгүүлж байжээ. Харин 2004 онд Консулын гэрлэлтийг бүртгэсэн **анкет** Монгол Улсын иргэний гэрлэсний улсын бүртгэлд ороогүй, харин архивд хадгалагдаж үлдсэн байна.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://shuukh.mn/single_case/3126?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс:** “... 2013 онд Ю.Б болон Т.Т нарын гэрлэлтийг бүртгэх цаг мөчид 2004 онд Л.Б-Э болон Т.Т нарын гэрлэлт нь хүчин төгөлдөр байсан, эсхүл хүчин төгөлдөр бус байсан гэдгийг Иргэний хэргийн шүүхээс тогтоосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр байхгүй байгаа тохиолдолд энэ үйл баримтыг **иргэний улсын бүртгэлийн байгууллага мэдэх боломжгүй.**”
2. “Харин ... 2013 онд Ю.Б болон Т.Т нарын гэрлэлтийг бүртгэх цаг мөчид гуравдагч этгээд Т.Т нь ИБУИНХУ-ын иргэншил авсан байсан нь хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт болон талуудын тайлбараар тогтоогдлоо. ... улмаар **1999 оны Иргэний бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7² дахь хэсэгт заасан тодруулах ажиллагааг хийж, нотлох баримтуудыг гаргуулан авах боломжтой байсан.** ... Хариуцагч нь дээрх үйл баримтыг нягтлан тодруулах боломжтой атал түүнийг тодруулахгүйгээр Ю.Б болон Т.Т нарын гэрлэснийг **бүртгэсэн нь хуульд нийцээгүй...**” гэж дүгнэж нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.
3. **Давж заалдах шатны шүүхээс:** “Анхан шатны шүүх “... иргэний улсын бүртгэлийн байгууллага мэдэх боломжгүй” гэж дүгнэсэн нь учир дутагдалтай ... **нөхцөл байдлыг нягтлан тодруулах байсан,** улмаар гуравдагч этгээдийн өмнөх гэрлэлттэй нь холбогдуулан Гэр бүлийн тухай хуулийн **9.1.1³-т заасны дагуу нэхэмжлэгч, гуравдагч этгээд нарын гэрлэлтийг бүртгэхээс татгалзах байсан** гэж үзэх үндэслэлтэй ...”
4. “... Харин анхан шатны шүүхийн “... Ю.Б болон Т.Т нарын гэрлэснийг бүртгэхдээ Т-ын Т нь гадаад улсын иргэн болсон гэдгийг мэдэх боломжтой байсан, тухайлбал Монгол Улсад оршин суух MNG дугаартай үнэмлэхийг мэдээллийн сангийн лавлагааны тусламжтайгаар мэдэх боломжтой байсан” гэж дүгнэсэн нь үндэслэлтэй. ...” гээд шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангаж, гуравдагч этгээдийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон.
5. **Гуравдагч этгээдийн зүгээс хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:** Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн гэх үндэслэлээр гомдол гаргасан.
6. **Хяналтын шатны шүүхээс:** 2004 онд Элчин сайдын яамны Консулын үйлдсэн ... Т овогтой Т гэх хүнийг гэрлэсэн гэх **Гэрлэснийг бүртгэх анкет нь 2013 онд Ю овогтой Б, Т овогтой Т нарын гэрлэсний бүртгэлийг хүчингүй болгох эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.** (16)⁴
7. Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “гэрлэлт гэж ... хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг /ойлгох/”-оор

² Иргэний бүртгэлийн тухай хууль (1999)-ийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг “Монгол Улсын харьяат иргэн гадаадын иргэнтэй, эсхүл гадаадын иргэд хоорондоо тус улсын нутаг дэвсгэр дээр гэрлэж бүртгүүлэхдээ энэ хуулийн 13.2-т заасан баримт бичгээс гадна тэдгээрийн өргөдлийн орчуулга, тухайн гадаадын иргэнийг харьяалсан улсын дипломат төлөөлөгчдийн болон консулын, эсхүл тухайн орны иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн газраас гаргасан тодорхойлолтыг хавсаргана.

Тодорхойлолтод гэрлэхийг хүсээчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, газар, байнга оршин суугаа газрын хаяг, гэрлэлтийн байдлыг бичсэн байна.”

³ Гэр бүлийн тухай хууль (1999)-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг “Дараахь байдал нь гэрлэхэд харшлах шалтгаан болно.” гээд 9.1.1 дэх заалт “өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;”.

⁴ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



заасан, 2004 онд Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад суугаа ЭСЯ-нд үйлдсэн Гэрлэснийг бүртгэх анкет 0007 гэх баримтаар Монгол Улсын иргэний гэрлэсний улсын бүртгэлд ямар нэг бүртгэл хийгдээгүй байхад “Т.Т-гийн өмнөх гэрлэлт нь хүчинтэй байгаа” гэх үндэслэлээр 2013 онд Ю.Б, Т.Т нарын гэрлэснийг бүртгэхээс улсын бүртгэлийн байгууллага татгалзах үндэслэлгүй, энэ талаарх хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шүүхэд ирүүлсэн тайлбар, татгалзал үндэслэлтэй. (17)

8. Давж заалдах шатны шүүх уг асуудлаар буруу дүгнэлт хийж, “...иргэний бүртгэлийг эрхлэн хариуцах чиг үүрэг бүхий Улсын бүртгэлийн байгууллага нь тухайн үед /2004 онд/ уг гэрлэлтийн бүртгэлийг хийх үүрэгтэй, уг бүртгэлийг үндэслэн Ю.Б, Т.Т нарын 2013 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр гаргасан гэрлэлт бүртгүүлэх өргөдлийг ... **бүртгэхээс татгалзах байсан**” гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна. (19)
9. Харьяатын тухай хуулийн 11 дүгээр зүйлд “энэ хуулиар тогтоосон журмын дагуу Монгол Улсын харьяат өөрийн хүсэлтийн дагуу Монгол Улсын харьяатаас гарч болно”, 24 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын ... харьяатаас гарах ... хүсэлтийг зөвшөөрөх тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг ... гаргана”, 25 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын харьяатаас гарсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсан өдрөөс хүсэлт гаргагчийг Монгол Улсын харьяатаас гарсанд тооцно” гэж тус тус зааснаас үзвэл “**гадаад улсын иргэний харьяалал авсан**” нь Монгол Улсын иргэнийг Монгол Улсын харьяатаас хасах, харьяатаас гарсанд тооцох үндэслэл болохгүй. (22)
10. Анхан болон давж заалдах шатны шүүхүүд **нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэхдээ 2013 онд эхнэр Т.Т-тай гэрлэснийг нь бүртгэсэн бүртгэлийн улмаас нөхөр Ю.Б-ын ямар эрх нь хэрхэн зөрчигдсэн талаар огт дүгнэлт хийлгүй хэргийг шийдвэрлэсэн** нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтуудад нийцээгүй гэж үзнэ. (27)
11. Нэхэмжлэгч талаас өөрийн зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхэд тодорхойлохдоо “... үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хүүхдүүдтэйгээ хамт амьдрах эрх зөрчигдсэн, ... гэрлэгчийн хувьд эдлэх эрх зөрчигдсэн” гэх боловч эдгээр үндэслэлд нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны хэргийн шүүх дүгнэлт хийхгүй. Өөрөөр хэлбэл, 2013 онд Ю.Б, Т.Т нарын гэрлэснийг улсын бүртгэлд бүртгэснээр Ю.Б-ын үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хүүхдүүдтэйгээ хамт амьдрах эрх болон гэрлэгчийн хувьд эдлэх эрхийг нь зөрчсөн гэж захиргааны хэргийн шүүх дүгнэх үндэслэлгүй, энэ талаарх нэхэмжлэгчийн тайлбар, үндэслэлийг хүлээж авахгүй. (30)
12. Дээрх үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, гуравдагч этгээдийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж, нэхэмжлэгч Ю.Б-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.